

УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



АУДИТЫН ЗОРИЛТ

2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулах



ХАМРАХ ХҮРЭЭ

- ✓ БОНХОБТХ
- ✓ Санхүү төрийн сангийн хэлтэс
- ✓ Худалдан авах ажиллагааны газар
- ✓ Орон нутгийн өмчийн газар
- ✓ Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
- ✓ сумдын Засаг даргын Тамгын газар
- ✓ Гүйцэтгэгч аж ахуй нэгжүүд



АУДИТЫН БАГ

Аудитын удирдах:
Х.Болдбаатар
Чанарын хяналт :
А.Цэцэгсүрэн
Аудитын баг:
• А.Нарандэлгэр
• Н.Батжаргал
• Т.Бат-Эрдэнэ
• Ц.Аззаяа

 ХУГАЦАА
2025 он

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналын 45 хувь нь төсөвлөлтийн шаардлагад бүрэн нийцээгүй байна

Цахим системээр хүргүүлсэн санал



62 САНАЛ
309,180.9 сая



34 САНАЛ
ХАНГАСАН
220,923.8 сая



28 САНАЛ
ХАНГААГҮЙ
88,257.1 сая



2025 оны улсын төсөвт батлагдсан төсөл

Ангилал	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Шинэ ТАХ	1	1,842.0	1,842.0
Шилжих ТАХ	27	376,364.8	122,985.4
Нийт	28	378,206.8	124,827.4

Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжихээс тусгагдаагүй төсөл



6 төсөл



85,3
тэрбум ₮

Сангийн яамнаас тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хянасан боловч дахин үнэлгээг хангалтгүй хийснээр шүүхрүү шилжиж төсөл арга хэмжээ удааширсан байна

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО



"ЭхЗ" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Ховд/






Эрүүл мэндийн төвийн барилга /Ховд, Цэцэг сум/




Хөрөнгө оруулалтын ажил зогссон, удаашралтай байгаа 3 төсөл арга хэмжээний гэрээг дүгнэн, хариу арга хэмжээ авснаар 15.5 тэрбум төгрөгөөр төсвийн үр өгөөж нэмэгдэхээр байна

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээ





Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 8 төсөл арга хэмжээний 27,182.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 20,925.8 сая төгрөгийн санхүүжилт ирж, 6,256.2 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний санхүүжилт дутуу ирсэн байна.








АУДИТЫН ДҮГНЭЛТ

 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналын 45 хувь нь төсөвлөлтийн шаардлагад бүрэн нийцээгүй байна

 Сангийн яамнаас тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хянасан шийдвэрийг үнэлж, холбогдох арга хэмжээг аваагүй байна

 Хөрөнгө оруулалтын ажил зогссон, удаашралтай байгаа 3 төсөл арга хэмжээний гэрээг дүгнэн, хариу арга хэмжээ авснаар 15.5 тэрбум төгрөгөөр төсвийн үр өгөөж нэмэгдэхээр байна

 Захиалагчийн болон зураг зохиогчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг бодитой дүгнэж, үүрэг хариуцлагыг сайжруулснаар төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна

 “Шинэ Ховд БХЖОНӨӨ” ХХК-ны хариуцсан тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах талаар хариу арга хэмжээ шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

- ❖ Гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг сум багц 1/, Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж /Ховд, Жаргалант сум/ ажлуудыг бүрэн гүйцэтгүүлэн хүлээн авч ашиглалтад оруулах,
- ❖ Багшийн хөгжлийн төвийн барилга, Бага сургуулийн барилга, Дотуур байрны барилга /Манхан сум/ зэрэг он дамжин хэрэгжиж дуусаагүй барилгуудын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж, хариу арга хэмжээ авч, ашиглалтад оруулах.
- ❖ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулж, комиссын гишүүдийг сонгохдоо ажиллах боломж мэдлэг, ур чадварыг харгалзан томилж, ажлыг нь дүгнэж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах.



БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭСТ

- ❖ Шинэ хөдөө төслөөр 2024 онд нийлүүлэгдсэн, ашиглагч нь тодорхойгүй 47 ширхэг оёдлын машиныг авсан эзэн холбогдогчийг тодорхой болгон ашиглалтын гэрээг байгуулах.
- ❖ Зураг зохиогчийн хяналт гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гаргуулан, хэрэгжилтийг бүрэн хангуулж, гэрээг дүгнэн бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олголог байх.



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

- ❖ Үнэлгээний хорооны гишүүд тендерийн үнэлгээг хуульд заасны дагуу үнэн зөв хийгээгүйгээс шүүхийн шийдвэрээр гүйцэтгэгчийг тодорхойлсон тохиолдолд буруу шийдвэр гаргасан үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцох.



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

- ❖ Хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгүүдийн баримт бичгийг бүрдүүлж орлого авах шийдвэрийг гаргуулахаар уламжлах, өмнөх онд хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, батлагдсан төсөвт өртөг нь магадлалаар нэмэгдсэн барилга байгууламжуудыг тодорхойлж, бүртгэсэн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэн данс бүртгэлд тусгах ажлын зохион байгуулах.



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ

- ❖ Барилгын улаан журналыг журамд заасны дагуу бүрэн хөтлүүлж, барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа албан хаагчийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, захиалагчийн хяналтыг чанартай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх.
- ❖ “Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд аймаг, Жаргалант сум/ төслийн зураг төсвийн дагуу хийгээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй байх, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чадамжийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах.
- ❖ Буянт, Мянгад, Зэрэг сумдад хэрэгжиж хүлээн авсан Ногоон байгууламж бүхий орчны тохижилтоор хийгдсэн хөрөнгө оруулалтын зарим нь эвдэрсэн, ажиллахгүй байгааг гүйцэтгэгчээр баталгаат хугацаанд нь засварлуулах.



ШИНЭ ХОВД БХХ ОНӨОХХК

- ❖ Дулуу хиигдсэн багаж тоног төхөөрөмж хадгалах байрыг хүлэмж цогцолборт бариулах, ашиглалтын шаардлага хангасан GPS хүлээн авч, суурилуулах.
- ❖ Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/-өөр нийлүүлэгдсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулан, үйлдвэрлэл ажлын байрыг нэмэгдүүлэн ажиллах.
- ❖ Шинэ хөдөө төслөөс иргэдэд ашиглуулж байгаа хөрөнгийн түрээсийн төлбөрийг төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлэх

Аудитаар нийт 5,653.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 44.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 840.9 сая төгрөгийн 5 зөрчил арилгуулах албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага тогтоон, 4,768.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 13 зөвлөмж өглөө



ТӨЛБӨРИЙН АКТ-1 44.1 сая төгрөг

🏠 Дотуур байрны барилга,
150 ор /Ховд, Манхан сум,
Төгрөг гол баг/

Гадна ханыг зураг төсвийн
дагуу хийгээгүй



ХАРИУЦЛАГА ТООЦОХ АЛБАН ШААРДЛАГА



Захиалагчийн хяналт хангалтгүй
хэрэгжүүлж, чанар болон шаардлага
хангаагүй ажлыг хүлээн авч, санхүүжилт
олгосон



ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ АЛБАН ШААРДЛАГА-5 840.9 сая төгрөг



Шинэ Ховд-2

Тоног төхөөрөмжийн угсралт,
сургалт тохируулга бүрэн
хийгдээгүй.



Олон угсаатны театр

Гулсах тулгуур суурилуулаагүй,
бетон дэрийг стандартын бус
материалаар хийсэн



Кино театр

Тоног төхөөрөмж, ногоон
байгууламж, авто замын ажил
бүрэн дуусаагүй.



Спорт заал



ногоон байгууламж,



Цэвэр, бохир усны



шугам сүлжээ

Ажил дутуу байхад хүлээн авч,
үлдэгдэл ажил, нөхөн сэргээлтийг
хийгээгүй.



Ус хангамж

Батлагдсан байршлыг өөрчилж,
хууль журмын дагуу зөвшилцөл
хийлгүй ажил
эхлүүлсэн.